



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 10

Есөнбулаг сум

Аймгийг 2021-2025 онд  
хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл  
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "е" заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл"-ийг 1 дүгээр хавсралтаар, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Аймгийг хөгжүүлэх таван жилийн Үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Амгаланбаатар)-д даалгасугай.


ДАРГА



Д.ДАВААДОРЖ

01010028

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2020 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн  
10 дугаар тогтоолын хавсралт



## ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

### Нэг.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

**Зорилго** 1.Алтайчуудын бахархал, үнэт зүйлийг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэн, нийгмийг соён гэгээрүүлнэ.

#### Алтайчуудын бахархал, эв нэгдэл

**Зорилт 1.1.**Алтайчуудын бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ.

1.1.1.Алтай нутгаас төрөн гарсан төр нийгмийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг алдаршуулж, бахархлыг сэргээж, эх оронч үзлийг төлөвшүүлнэ.

1.1.2.Түүх, байгалийн дурсгалт газар, ан амьтдыг түшиглэн зорилтот аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.

#### Өв соёл, ёс заншил

**Зорилт 1.2.**Монгол ахуй, өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлж, соёлын биет болон биет бус өвийг хойч үе хүүхэд, залуучуудад өвлөн уламжлуулна.

1.2.1.Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.

1.2.2.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон хүмүүжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг цэцэрлэг, сургуульд хэрэгжүүлнэ.

1.2.3.Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, төрлийг өргөжүүлж, соёлын өвийн бүртгэл, мэдээлэл, хадгалалт хамгаалалт, сурталчилгааг нэмэгдүүлж, нутгийн онцлогийг илэрхийлсэн соёл урлагийн нэрийн /брэнд/ ажил үйлчилгээг бий болгоно.

1.2.4.Гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн удам угсаагаа мэдэх угийн бичиг хөтлөх иргэний үүргээ биелүүлэх ажлыг зохион байгуулна.

#### Монгол хэл, бичиг

**Зорилт 1.3.**Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.

1.3.1.Монгол хэл, бичиг арга хэмжээг хэрэгжүүлж, бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.

1.3.2.Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

## **ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ**

**Зорилго 2.**Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж, хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн, эрүүл дадал хэвшилтэй, нийгмийн идэвхтэй, эрүүл хүнийг хөгжүүлнэ.

### **Эрүүл мэнд**

**Зорилт 2.1.**Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд тасралтгүй хүртээмжтэй, чанартай хүргэх үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлнэ.

2.1.1.Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авах чадавхыг бүрдүүлнэ.

2.2.2.Хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, үзлэг оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг дадал болгон сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.

2.1.3.Оношилгоо, эмчилгээний уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлснээр иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээлийг бууруулна.

2.1.4.Яаралтай тусламжийн чанар хүртээмж, чадавхийг сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.

2.1.5.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн аргыг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын үр ашгийг дээшлүүлнэ.

2.1.6.Цахим үйлчилгээг өргөжүүлж, оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг нэвтрүүлнэ.

2.1.7.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын цахим тогтолцоог нэвтрүүлж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.1.8.Хүний нөөцийн чадавхыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.

2.1.9.Эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан үйлчлүүлэгчдэд ээлтэй, аюулгүй, стандарт хангасан орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Боловсрол**

**Зорилт 2.2.**Монгол хүний хүмүүжил, хэл, соёл, өв уламжлалаа эрхэмлэн, дээдэлсэн эрдэм мэдлэгтэй иргэн төлөвшүүлнэ.

2.2.1.Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 91 хувьд, ерөнхий боловсролын хамран сургалтыг 98.6 хувьд хүргэнэ.

2.2.2.Ерөнхий боловсролыг тэгш хүртээмжтэй эзэмших боломж бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.

2.2.3.Боловсролын салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн баталгааг сайжруулна.

2.2.4.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, шударга ёсны үзэл, хандлага болон хүмүүжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

2.2.5.Боловсролын салбарын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлнэ.

2.2.6.Цахим сургалтыг хөгжүүлэх, цахим сургалтын хөтөлбөр, агуулга, хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжиж, орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2.7.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг хүүхэд, багшийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангана.

### **Гэр бүл**

**Зорилт 2.3.**Нийгмийн бүх орчинд гэр бүл, хүүхэд, залуучуудын аливаа эрх зөрчигдөх, хүчирхийлэл, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, хариу үйлчилгээ үзүүлэн, хариуцлага ёс зүйтэй өсвөр үе, залуучуудыг төлөвшүүлэх орчин нөхцөлийг сайжруулна.

2.3.1.Хүүхэд, гэр бүл, залуучуудын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй зөвлөл, хороодын гишүүд, хүүхдийн төлөө ажиллагсдыг чадавхжуулан, арга зүйн дэмжлэг үзүүлж салбар дундын уялдаа холбоог ханган ажиллана.

2.3.2.Эрх нь зөрчигдсөн хүүхэд, гэр бүл, залуучуудыг хариу үйлчилгээнд хамруулж, нөхөн сэргээх, хамгаалах олон талт цогц үйлчилгээг сум, багийн түвшинд үзүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.3.3.Өсвөр үе, залуучууд, гэр бүлийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, санал санаачлагыг дэмжих, хөгжил оролцоог хангасан орчинг бүрдүүлнэ.

2.3.4.Хөгжилтэй андууд зусланг их засварт оруулан үйл ажиллагааг тогтмолжуулж, "Засагт ханы хот айл гэр зуслан"-г сум бүрт байгуулан хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.

### **Биеийн тамир, спорт**

**Зорилт 2.4.**Нийтийн биеийн тамирыг хүн амын хэрэглээ болгон эрүүл аж төрөх дадалд хэвшүүлж, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулан олон улс, тив дэлхийд өрсөлдөх чадвартай тамирчдыг бэлтгэнэ.

2.4.1.Нийтийн биеийн тамираар хичээллэгчдийн тоог нэмэгдүүлж, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсдын тоог ахиулна.

2.4.2.Спортын төрлүүдийг шинээр хөгжүүлж, тогтмол хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ.

2.4.3.Биеийн тамир спортын заал, гадна талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.4.4."Аваргыг аймагтаа" арга хэмжээг хэрэгжүүлж, тамирчдыг бүс, улс, олон улсын уралдаан, тэмцээнд оролцуулж ур чадварыг нэмэгдүүлнэ.

2.4.5.Усан спорт, чийрэгжүүлэлтийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмжөөр ханган, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.

2.4.6.Бүс, улсын аварга шалгаруулах тэмцээнийг аймаг орон нутагтаа 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

#### **Хүнд ээлтэй амьдрах орчин**

**Зорилт 2.5.**Эрүүл баталгаат орчныг бий болгоно.

2.5.1.Алтай хотын соёл амралтын хүрээлэнг өргөжүүлж, цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтыг сайжруулна.

2.5.2.Есөнбулаг сумд “Хөгжлийн гудамж” төслийг хэрэгжүүлж, Алтай хотыг орчин үеийн хот болгох суурийг эхлүүлнэ.

2.5.3.Стандартын шаардлага хангасан хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлнэ.

2.5.4.Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.5.5.Сум, суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж усалгаа, арчилгаа, хамгаалалтыг олон нийтийн оролцоотойгоор шийдвэрлэнэ.

2.5.6.Алтай хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2.5.7.Сумдын шинэчлэл арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

#### **Шинжлэх ухаан, технологи инноваци**

**Зорилт 2.6.**Шинжлэх ухаан, технологи, инновацийг нутагшуулна.

2.6.1.Шинжлэх ухаан, технологи, инновацийн зөвлөл байгуулж, шинэ техник, технологийг нэвтрүүлнэ.

### **ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА**

**Зорилго 3.**Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг сайжруулна.

#### **Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес**

**Зорилт 3.1.**Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн “Иргэн бүрт орлого-Өрх бүрт өсөлт” арга хэмжээг зохион байгуулж, 1000-аас доошгүй байнгын ажлын байрыг шинээр бий болгож, ажилгүйдлийн түвшинг жилд дунджаар 0,5 хувиар бууруулна.

3.1.1.Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай бүх төрлийн дэмжлэг, туслалцааг үзүүлэх, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.

3.1.2.Өрхийн болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангаж, бизнес инкубаторын үйлчилгээ үзүүлнэ.

3.1.3.Малчдын ажлын байрны тогтвортой байдлыг хадгалж, орлогын эх үүсвэртэй болгоно.

3.1.4.Зорилтот бүлгийн өрх, иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэн, тэдний онцлогт нийцүүлсэн байнгын ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

3.1.5.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн 2021-2025 оны тоон судалгааг хийж, үр дүнд үндэслэн мэргэжилтэн ажилтан бэлтгэнэ.

3.1.6.Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тооллогыг зохион байгуулж, бүртгэл, мэдээллийг сайжруулна.

#### **Нийгмийн хамгаалал ба даатгалын тогтолцооны шинэчлэл**

**Зорилт 3.2.**Нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, иргэдийн нийгмийн баталгаа, амьжиргааг дээшлүүлнэ.

3.2.1.Өрхийн амьжиргааны түвшинг шинэчлэн тогтоож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, халамж хүртэгч иргэдийн хүрээг багасгаж, ядуурлыг бууруулна.

3.2.2.Хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг үзүүлнэ.

3.2.3.Нийгмийн даатгалын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, даатгалын албан журмын болон сайн дурын даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

3.2.4.Татварт бүртгэлтэй үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй аж ахуйн нэгжийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ.

#### **Орлогод нийцсэн орон байр**

**Зорилт 3.3.**Стандартын шаардлага хангасан хямд өртөгтэй орон сууцаар иргэдийг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.1.Алтай хотын Солонго хорооллын инженерийн дэд бүтцийн угсралтын ажлыг ашиглалтад оруулж, иргэд, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангана.

3.3.2.Сумдын инженерийн шугам сүлжээний дэд бүтцийг шийдвэрлэж, сум бүрт орон сууц барих нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.3.Зорилтот бүлгийн иргэдийг "Түрээсийн орон сууц"-аар хангах бодлогыг баримтална.

3.3.4.Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордыг түшиглэн хайрга, дайрга, элсний нөөцийг тогтоож, барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэн барилга байгууламжийн насжилт, чанарыг сайжруулна.

3.3.5.Барилгын материалын лабораторийн үйл ажиллагааг өргөжүүлж, хийгдэх сорил шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлсэнээр стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ.

#### **Газрын харилцаа**

**Зорилт 3.4.**Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

3.4.1.Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан аймаг, сумын газар зохион байгуулалтын хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, мөрдүүлнэ.

3.4.2.Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг иргэдийн оролцоотой боловсруулж, газар олголтыг ил тод нээлттэй болгоно.

3.4.3.Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг сумдын түвшинд нэвтрүүлж, ашиглана.

3.4.4.Газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын систем бий болж, газрыг хамгаалах, нөхөн сэргээнэ.

3.4.5.Хаягжилтын нэгдсэн системийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулна.

## **ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ**

**Зорилго 4.**Хөдөө аж ахуй, аялал жуулчлал, хариуцлагатай уул уурхай, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих замаар төр хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн өсөлтийн бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангахад чиглэсэн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

### **Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүд**

#### **Тогтвортой хөдөө аж ахуй, үйлдвэрлэл**

**Зорилт 4.1.**Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангана.

4.1.1.“Газар тариалан, жимс, жимсгэнэ” төслийг хэрэгжүүлнэ.

4.1.2.Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хүнсний нарийн ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.1.3.Төмс, хүнсний ногоо, үрийн нөөцийг хадгалах зоорийн аж ахуйг хөгжүүлнэ.

4.1.4.Хүнсний аюулгүй байдлыг хангаж, мах, сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.1.5.Стандартын шаардлага хангасан мал нядалгааны цех, хөргүүртэй агуулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг бүсчлэн хөгжүүлнэ.

4.1.6.Худалдаа, нийтийн хоол, хоршоо, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг бодлогоор дэмжиж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.

4.1.7.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулан, хөнгөлөлттэй зээл авахад дэмжлэг үзүүлж, Бизнес мэдээлэл, судалгаа хөгжлийн “GATE CENTER” төвийг байгуулна.

4.1.8.Малын чанар, ашиг шимийг сайжруулан, генийн санг хамгаалж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ.

4.1.9.Малын гоц халдварт өвчингүй “Эрүүл бүс” нутгийг хадгалж, мал амьтны эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.1.10.Бэлчээрийн менежмент хөтөлбөрийг хэрэгжүүлж, бэлчээрийг доройтлоос хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтыг сайжруулна.

4.1.11.Мал сүргийг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалан аймаг, сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлнэ.

## **Аялал жуулчлал**

**Зорилт 4.2.** Байгаль, түүх, соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.2.1. Орон нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын шинэлэг, брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

4.2.2. Монголд төдийгүй дэлхийд ховордсон нэн ховор, ховор амьтдыг түшиглэсэн тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

4.2.3. Байгалийн үзэсгэлэнт тогтоц бүхий газруудыг түшиглэн аялал жуулчлалын баазыг шинээр байгуулна.

4.2.4. Аялал жуулчлалын салбарын үйлчилгээний байгууллагуудын хүчин чадал, үйлчилгээг сайжруулж, жуулчдын амрах, үйлчлүүлэх ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.5. Элсний фестиваль эвент арга хэмжээг улс үндэстний хэмжээн дэх брэнд эвент болгож хөгжүүлнэ.

4.2.6. Аялал жуулчлалын салбарын чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, ур чадварыг нэмэгдүүлнэ.

4.2.7. Аялал жуулчлалын гол маршрутыг шинэчлэн баталж, цахилгаан хангамж, авто замын дэд бүтцийг сайжруулна.

## **Уул уурхай**

**Зорилт 4.3.** Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

4.3.1. Ашигт малтмалын томоохон ордуудыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

4.3.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын илэрцийн нөөцийн судалгааг хийж, орд газрын нөөцийг тогтоон барилгын материалын үйлдвэрлэлийг стандартад нийцсэн түүхий эдээр хангана.

4.3.3. Үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн нийгмийн хариуцлагыг сайжруулж, орон нутгийн хөгжилд оролцох оролцоог сайжруулна.

4.3.4. Нэгдсэн зохион байгуулалтад орсон бичил уурхай эрхлэгчдийг дэмжинэ.

## **Бүс нутгийн хамтын ажиллагаа**

**Зорилт 4.4.** Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

4.4.1. Гадаад бодлогын залгамж чанар, нэгдмэл байдлыг хадгалж, харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, шинэ гарц нээх асуудлыг судална.

4.4.2. Олон улсын төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

## **ТАВ.ЗАСАГЛАЛ**

**Зорилт 5.**Төрийн үйлчилгээг цахимжуулж, авлига, ашиг сонирхлын зөрчил, гэмт хэрэг, болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэн, батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, иргэний оролцоотой, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой, үр нөлөөтэй засаглалын бодлого хэрэгжүүлнэ.

#### **Төрийн үйлчилгээ**

**Зорилт 5.1.**Төрийн үйлчилгээний шат дамжлагыг бууруулж, ил тод, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлнэ.

5.1.1.Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.

5.1.2.“Цахим-Алтай” арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.

5.1.3.Төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, сахилга хариуцлагыг сайжруулна.

5.1.4.Сумдыг улсын бүртгэлийн онлайн системд холбох ажлыг үргэлжлүүлнэ.

5.1.5.Төрийн архивыг зориулалтын байртай болгож, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.

5.1.6.Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулахад дэмжлэг үзүүлнэ.

#### **Авлигагүй засаглал**

**Зорилт 5.2.**Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид засаглалын бодлогыг хэрэгжүүлнэ.

5.2.1.Төрийн үйл ажиллагааны бүх шатанд хуулийн зөв хэрэглээг төлөвшүүлж, авлигыг таслан зогсоох, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, урьдчилан сэргийлэхэд төр, иргэн, иргэний нийгмийн байгууллагуудын мэдээлэл солилцох тогтолцоог бүрдүүлнэ.

5.2.2.Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, зөрчлийг бууруулах, бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлнэ.

#### **Төсөв, санхүү**

**Зорилт 5.3.**Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлнэ.

5.3.1.Төсвийг төлөвлөх хэрэгжүүлэх, тайлагнах бүхэл үе шатанд иргэдэд нээлттэй байж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулна.

5.3.2.Татварын бааз суурийг өргөжүүлэн, хамрагдалтын түвшинг нэмэгдүүлнэ.

5.3.3.Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдэлийг бага түвшинд хүргэнэ.

5.3.4.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын менежментийг сайжруулж, алдагдлыг бууруулна.

## ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ

**Зорилго 6.** Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

### **Эх байгаль анхдагч экосистем**

**Зорилт 6.1.** Экосистемийн чухал ач холбогдол бүхий газар нутгуудыг тусгай хамгаалалтад авч, хамгааллын загвар менежментийг бий болгоно.

6.1.1. Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж 60 хувьд хүргэнэ.

6.1.2. Улс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн загвар менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын түншлэлийн зарчмаар хамгаална.

### **Байгалийн баялгийн үр өгөөж**

**Зорилт 6.2.** Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зүй зохистой ашиглах, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомстлыг бууруулан, ногоон хөгжлийн замаар байгаль хамгаалалд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

6.2.1. Цөлжилт эрчимтэй явагдаж буй газрууд, төв суурин газарт салхинаас хамгаалах зорилгоор ойжуулах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлж 100 га-аас доошгүй талбайд хийж гүйцэтгэнэ.

6.2.2. Төв суурин газрын ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа хамгаалалтыг цогцоор шийдвэрлэж, амьдралтын хувийг 90-өөс доошгүй хувьд хүргэнэ.

6.2.3. Заган ой бүхий 10 сумын 1.6 сая га талбайд ой зохион байгуулалтын судалгааны ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж үр дүнд үндэслэн нөхөн сэргээх, үржүүлэх, ойжуулах ажлыг хийнэ.

6.2.4. Шинэсэн ойд байгалийн сэргэн ургалтыг дэмжих ажлыг 15 га талбайд, ойн хөнөөлт шавж өвчинтэй тэмцэх ажлыг 1900 га талбайд, ойн цэвэрлэгээний ажлыг 500 га талбайд зохион байгуулна.

6.2.5. Монгол бөхөнг Улаан шалын хоолойд, Халиун бугыг Хантайширын нуруунд, Монгол тарвагыг Шарга, Баян-Уул, Есөнбулаг сумдад сэргээн нутагшуулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

6.2.6. Сумдад хийгдсэн агнуур зохион байгуулалтын нарийвчилсан төлөвлөгөөний дагуу агнуурын бүс нутгийг шинээр ашиглана.

6.2.7. Элсний нүүлт эрчимтэй явагдаж буй Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдын 20-иос доошгүй га талбайд элсний нүүлтийг сааруулах механик хамгаалалтыг турших, нүүсэн үржил шимгүй элсийг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг судална.

6.2.8. Газрын доройтол, цөлжилтийн нөлөөллөөс тархац нь багассан суль, цулхир, хармаг зэрэг ашигт ургамлыг Хөхморьт, Шарга, Цогт, Эрдэнэ сумдад 20-иос доошгүй га талбайд тарималжуулан, нөхөн тарих замаар хөрсний үржил шимийг нэмэгдүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулна.

6.2.9. Дэд бүтэц, уул уурхай, хууль бусаар ашигт малтмал олборлогч иргэдийн үйл ажиллагаанаас болж эвдэрсэн газрын хэмжээг нөхөн сэргээлт хийх замаар үе шаттайгаар бууруулна.

#### **Үнэт баялаг ус**

**Зорилт 6.3.** Усны нөөц эх үүсвэрүүдийг тогтоон, гадаргын усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усыг бохирдол, хомсдолоос хамгаалан сумдын хүн амын ундны цэвэр усны хангамжийн асуудлыг шийдвэрлэж, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.

6.3.1. Хүн амын усан хангамжийн эх үүсвэрийн эрэл, хайгуулын ажлыг хийж, нөөцийг тогтоон, ундны усны чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах бодлогыг олон улсын төсөл, хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

6.3.2. Хот, суурин газрын усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулж, усны нөөц бохирдож, хомстохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.3. Хөрсний үржил шим, чийгийг ойн зурвас, хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хаших замаар хамгаална.

#### **Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил**

**Зорилт 6.4.** Орчны бохирдлыг бууруулах зорилгоор байгальд ээлтэй хэмнэлттэй, дэвшилтэт технологи нэвтрүүлнэ.

6.4.1. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах цогц үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.

6.4.2. Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор жуулчны бааз, төв суурин газрын гэр хорооллын айл өрхүүдийг эрүүл ахуйн стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжтай болгоно.

6.4.3. Төв суурин газрын гэр хорооллын айл өрхүүдэд “Эрчим хүчний хэмнэлттэй Монгол гэрийн дулаалга” шийдлийг нэвтрүүлнэ.

6.4.4. Төв суурин газрын орчны бохирдлыг бууруулах, иргэдийн тав тухтай амьдрах орчинг бүрдүүлэх зорилгоор сэргээгдэх эрчим хүч, шинэ техник технологид тулгуурласан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.4.5. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж, дэвшилтэд технологийг нэвтрүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.

### **ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ**

**Зорилго 7.** Батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

#### **Батлан хамгаалах**

**Зорилт 7.1.**Батлан хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэн иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

7.1.1.Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг шинэчлэн, иргэд, төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудад шалган туслах ажлыг зохион байгуулж иргэний цэргийн үүргийн биелэлтийг хангуулна.

7.1.2.Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж, оюутан цэргийн тоог нэмэгдүүлнэ.

7.1.3.Барилга-инженерийн цэргийн анги байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.

#### **Хүн, нийгмийн амар тайван байдал**

**Зорилт 7.2.**Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, нийгмийн дэг журмыг сахиулан, иргэдийн аюулгүй байдлыг хангана.

7.2.1.Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлж, мал хулгайлах, архидан согтуурах, согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.

7.2.2.Аймаг, сумдын төвийн гэр хорооллын хяналтын камертай гудамжны тоог нэмэгдүүлнэ.

#### **Гамшгаас хамгаалах**

**Зорилт 7.3.**Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг авч хэрэгжүүлнэ.

7.3.1. Гамшгийн бэлэн байдлын бодлого төлөвлөлтийг шинэчилж, гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг богино хугацаанд арилгах менежментийг хэрэгжүүлнэ.

7.3.2.Есөнбулаг сумд эрэн хайх, аврах салбар, Цогт сумд эрэн хайх, аврах бүлгийг байгуулна.

7.3.3.Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлж, техник хэрэгслийн чадавхыг нэмэгдүүлнэ.

#### **Мэргэжлийн хяналт**

**Зорилт 7.4.**Эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийнэ.

7.4.1.Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хийж, иргэдийн эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдлыг хангана.

### **НАЙМ. ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ**

**Зорилго 8.**Алтай хот болон сум, суурин газрын дэд бүтэц, хот байгуулалтын асуудлыг уур амьсгалын өөрчлөлттэй уялдуулан шийдвэрлэж, "Сумдын шинэчлэл-хөдөөгийн хөгжил" төслийг хэрэгжүүлнэ.

#### **ДЭД БҮТЭЦ:**

##### **Эрчим хүч**

**Зорилт 8.1.**Аймгийн төв болон сумдын цахилгаан, дулааны эрчим хүчний хангамж, хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

8.1.1.Алтай хотод баригдах дулааны станцыг ашиглалтад оруулж, 2-р хэлхээний шугам сүлжээг шинэчилж хэрэглээний халуун устай болгоно.

8.1.2.Сумдын төвийг төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системтэй болгоно.

8.1.3.Тайшир-Есөнбулаг чиглэлийн 35 кВт-ын ЦДАШ-ыг 110 кВт болгон өргөтгөж аймгийн төв болон сумдын цахилгаан эрчим хүчний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

8.1.4.Төвлөрсөн суурин газар болон зарим сумдын багийн төвийг байнгын эрчим хүчний эх үүсвэрт холбоно.

8.1.5.Алтай хотын гэр хороололд хоёр тарифт цахилгаан тоолуур суурилуулж, хэрэглэгчдэд ээлтэй систем нэвтрүүлнэ.

8.1.6.Алтай хотод 10МВт-ын нарны цахилгаан станц барьж ашиглалтад оруулна.

8.1.7.Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр барих хувийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

8.1.8.Алтай сумыг эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгоно.

8.1.9.Аймаг, сумын төвийн 0.4 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл шинэчлэл хийж, гэр хорооллын шинэ суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг сайжруулна.

### **Зам, тээвэр**

**Зорилт 8.2.**Улсын болон орон нутгийн чанартай авто зам, гүүрний засвар, арчлалт, ашиглалт болон тээврийн салбарын дэд бүтцийг хөгжүүлнэ.

8.2.1.Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан хатуу хучилттай авто замыг барьж ашиглалтад оруулна.

8.2.2.“Дугуйн болон явган хүний зам” төслийг хэрэгжүүлнэ.

8.2.3.Алтай хот-Бургастайн боомт чиглэлийн 320 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

8.2.4.Алтай-Улиастай чиглэлийн 194 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг барьж, ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлнэ.

8.2.5.Алтай хотод “Автовокзал”-ын барилгыг шинээр ашиглалтад оруулж тээврийн үйлчилгээг сайжруулна.

8.2.6.Алтай хотын төвийн хатуу хучилттай автозамын үерийн ус зайлуулах байгууламжийг шинээр бий болгоно.

8.2.7.Орон нутгийн чанартай авто зам, гүүрийн байгууламжийн засвар арчлалтыг үе шаттайгаар гүйцэтгэнэ.

### **Мэдээлэл, харилцаа холбоо**

**Зорилт 8.3.**Мэдээлэл харилцаа холбооны дэд бүтцийг хөгжүүлнэ.

8.3.1.Алтай сум, Баянтоорой тосгоныг өндөр хурдны интернетийн шилэн кабелийн сүлжээнд холбож, интернетийн цахим үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

8.3.2.Өндөр хурдны телевизийн сигнал дамжуулах “IPTV” технологи сумдад нэвтрүүлнэ.

8.3.3. Сум суурин болон алслагдсан багуудад үүрэн холбооны 3G, 4G сүлжээнд холбоно.

#### **Барилга, хот байгуулалт**

**Зорилт 8.4.** Аймаг, сумдын төвийн хот төлөвлөлтийг боловсронгуй болгож, хөгжүүлнэ.

8.4.1. Алтай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан шинэ суурьшлын бүсүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, хот төлөвлөлтийг сайжруулна.

